

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2023/05/НА-СТА-ТШЗ

Чингис хот  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Н.Туяа Утас: 99799709

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2023. 3. 13 № 266  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 6,263.9 сая төгрөг, авлага 7,640.8 сая төгрөг, бараа материал 6.5 сая төгрөг, үндсэн хөрөнгө 381.7 сая төгрөг, өр төлбөр 83.6 сая төгрөг, урьдчилж орсон орлого 88.9 сая төгрөгийн, нийт 14,292.9 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд 89,634.8 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 36,287.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 103.1 сая төгрөгийн орлого төвлөрч, нийгмийн даатгалын сангийн санхүүжилт 8,380.2 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлын 850.4 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Урсгал үйл ажиллагааны зардалд 794.0 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг /нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж/ 80,161.9 сая төгрөг зарцуулж, үйл ажиллагааны зардлаас 56.4 сая төгрөг хэмнэж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй бүртгэлд 1,551.9 мянган төгрөгөөр илүү, үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1,903.8 мянган төгрөгөөр дутуу, хувь хүний орлогын албан татварын авлагыг 1,692.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн, нийт 5,148.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа.

232330185

## **Бусад асуудлын хэсэг**

Бусад асуудлын хэсэгт анхаарах асуудал илрээгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,131,693,819.43</b>	<b>13,911,274,306.85</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>6,945,966,585.89</b>	<b>6,263,956,442.53</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>6,945,966,585.89</b>	<b>6,263,956,442.53</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>6,945,966,585.89</b>	<b>6,263,956,442.53</b>
31211	Төрийн сангийн харилцах	3,476,650.75	743,864.17
31213	Арилжааны банк дахь харилцах	6,942,489,935.14	6,261,121,011.03
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0	2,091,567.33
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>5,175,507,792.14</b>	<b>7,640,840,910.32</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	586,423,590.69	3,877,381,355.89
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,521,716,877.97	3,704,531,129.97
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>67,367,323.48</b>	<b>58,928,424.46</b>
33510	Байгууллагаас авах авлага	67,367,323.48	58,928,424.46
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,219,441.40</b>	<b>6,476,954.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>10,219,441.40</b>	<b>6,476,954.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,199,100.00	741,750.00
35420	Аж ахуйн материал	3,937,000.00	3,883,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,043,100.00	0
35440	Түлш, шатах тослох материал	2,824,799.00	732,186.00
35470	Бусад хангамжийн материал	1,215,442.40	1,119,418.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>325,698,361.46</b>	<b>381,681,960.83</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>325,698,361.46</b>	<b>381,681,960.83</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>305,048,361.46</b>	<b>361,031,960.83</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	283,639,655.00	283,639,655.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-45,267,444.19	-52,953,165.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,980,000.00	89,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,981,111.11	-89,980,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	135,413,102.38	147,771,317.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,207,593.64	-34,689,482.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,930,500.00	67,725,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,458,746.98	-50,461,863.50
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>20,650,000.00</b>	<b>20,650,000.00</b>
39301	Программ хангамж	7,504,571.00	7,504,571.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,504,571.00	-7,504,571.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,650,000.00	20,650,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>12,457,392,180.89</b>	<b>14,292,956,267.68</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>265,115,671.06</b>	<b>172,571,593.37</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>265,115,671.06</b>	<b>172,571,593.37</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>91,947,333.79</b>	<b>83,642,841.46</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	91,947,333.79	83,642,841.46
<b>41400</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	<b>173,168,337.27</b>	<b>88,928,751.91</b>
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	173,168,337.27	88,928,751.91
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,192,276,509.83</b>	<b>14,120,384,674.31</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>12,192,276,509.83</b>	<b>14,120,384,674.31</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	284,367,256.89	284,367,256.89
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	284,367,256.89	284,367,256.89
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>11,897,162,204.94</b>	<b>13,825,270,369.42</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	10,562,191,133.52	11,891,777,416.69
51220	Тайлант үеийн үр дүн	1,334,971,071.42	1,933,492,952.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,747,048.00	10,747,048.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>12,457,392,180.89</b>	<b>14,292,956,267.68</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>70,461,082,750.48</b>	<b>92,230,925,317.78</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>38,190,579,510.44</b>	<b>39,648,514,120.32</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>38,190,579,510.44</b>	<b>39,648,514,120.32</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	27,129,084,323.38	27,221,323,678.46
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,537,009,107.08	2,835,727,939.75
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,301,722,770.36	2,548,071,482.73
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	479,758,631.34	545,257,310.50
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,743,004,678.28	6,498,133,708.88
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>129,494,299.04</b>	<b>85,874,304.65</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>129,494,299.04</b>	<b>85,874,304.65</b>
120002	Хүүгийн орлого	9,827,246.41	0
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>17,241,555.56</b>	<b>25,904,953.85</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,877,555.56	25,748,953.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	364,000.00	156,000.00
120009	Бусад орлого	97,793,083.07	45,631,097.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,392,414.00	14,338,253.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	240,000.00	0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>32,141,008,941.00</b>	<b>52,496,536,892.81</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>0</b>	<b>7,563,748,952.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	7,563,748,952.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>455,100.00</b>	<b>0</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,100.00	0
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>31,380,474,041.00</b>	<b>44,082,405,940.81</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,380,474,041.00	44,082,405,940.81
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>760,079,800.00</b>	<b>850,382,000.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	760,079,800.00	841,281,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	9,100,900.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>69,126,111,679.06</b>	<b>90,297,432,365.05</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>69,126,111,679.06</b>	<b>90,297,432,365.05</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>775,948,621.17</b>	<b>722,003,745.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>549,265,899.10</b>	<b>548,321,073.67</b>
210101	Үндсэн цалин	427,161,744.10	403,387,630.98
210102	Нэмэгдэл	94,156,155.00	92,809,686.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,308,000.00	26,004,000.00
210104	Урамшуулал	8,640,000.00	26,119,756.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,049,624.95</b>	<b>69,489,333.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,851,135.51	47,638,347.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,547,821.12	5,689,808.78

**Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,438,256.90	4,588,189.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,109,564.22	1,051,279.07
210205	Эрүүл мэндийн даатгал	11,102,847.20	10,521,708.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,878,500.00</b>	<b>34,464,826.91</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,950,000.00	3,891,868.91
210302	Түлш, халаалт	23,113,000.00	28,825,025.00
210303	Цэвэр, бохир ус	1,815,500.00	1,747,933.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,658,220.85</b>	<b>23,229,086.85</b>
210401	Бичиг хэрэг	4,865,300.00	6,537,310.00
210402	Тээвэр, шатахуун	10,796,263.00	12,143,513.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,671,757.85	1,787,463.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	814,000.00	332,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,510,900.00	2,428,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,627,000.00</b>	<b>3,386,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	627,000.00	2,448,400.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	938,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,834,700.00</b>	<b>1,109,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,834,700.00	1,109,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>40,079,880.60</b>	<b>16,479,339.40</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,079,600.00	4,846,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	649,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	92,700.00
210807	Газрын төлбөр	20,650.00	20,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,677,860.00	6,851,680.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,572,270.60	1,518,634.40
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>57,554,795.67</b>	<b>25,524,385.24</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,274,122.00	162,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,280,673.67	25,362,385.24
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,350,163,057.89</b>	<b>89,575,428,619.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,122,634,467.00</b>	<b>80,257,522,601.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	60,111,037,167.00	80,141,353,577.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,597,300.00	8,115,824.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	108,053,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,227,528,590.89</b>	<b>9,317,906,018.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,227,528,590.89	9,317,906,018.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,334,971,071.42</b>	<b>1,933,492,952.73</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,334,971,071.42</b>	<b>1,933,492,952.73</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>69,642,911,102.06</b>	<b>89,634,783,496.54</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>37,367,527,185.83</b>	<b>36,287,027,030.70</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	<b>37,367,527,185.83</b>	<b>36,287,027,030.70</b>
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,768,023,611.29	24,917,836,101.05
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,322,038,894.92	2,591,369,884.66
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,104,811,144.34	2,329,223,451.24
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	440,578,478.23	496,275,143.81
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,732,075,057.05	5,952,322,449.94
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>97,654,816.23</b>	<b>103,150,865.84</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>97,654,816.23</b>	<b>103,150,865.84</b>
120002	Хүүгийн орлого	9,827,246.41	0
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>87,827,569.82</b>	<b>103,150,865.84</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,463,569.82	102,994,865.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	364,000.00	156,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>32,177,729,100.00</b>	<b>53,244,605,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>47,194,200.00</b>	<b>8,380,248,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,194,200.00	8,380,248,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>455,100.00</b>	<b>0</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,100.00	0
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	<b>31,370,000,000.00</b>	<b>44,013,975,600.00</b>
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,370,000,000.00	44,013,975,600.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>760,079,800.00</b>	<b>850,382,000.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	760,079,800.00	841,281,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	9,100,900.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>69,173,301,394.90</b>	<b>90,316,793,639.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>69,173,301,394.90</b>	<b>90,316,793,639.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>721,354,725.13</b>	<b>684,763,264.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>549,265,899.10</b>	<b>548,532,200.64</b>
210101	Үндсэн цалин	407,685,955.10	403,598,757.95
210102	Нэмэгдэл	113,631,944.00	92,809,686.01
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,308,000.00	26,004,000.00
210104	Урамшуулал	8,640,000.00	26,119,756.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>72,049,624.95</b>	<b>69,489,333.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,851,135.51	47,638,347.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,547,821.12	5,689,808.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,438,256.90	4,588,189.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,109,564.22	1,051,279.07
210205	Эрүүл мэндийн даатгал	11,102,847.20	10,521,708.82



**Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>28,878,500.00</b>	<b>27,540,701.91</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,950,000.00	3,891,868.91
210302	Түлш, халаалт	23,113,000.00	21,900,900.00
210303	Цэвэр, бохир ус	1,815,500.00	1,747,933.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,906,657.85</b>	<b>20,625,723.85</b>
210401	Бичиг хэрэг	6,016,400.00	6,079,960.00
210402	Тээвэр, шатахуун	12,473,300.00	10,050,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,671,757.85	1,787,463.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	814,000.00	332,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,931,200.00	2,375,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,670,100.00</b>	<b>2,343,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,670,100.00	1,405,300.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	938,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,834,700.00</b>	<b>1,109,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,834,700.00	1,109,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,475,121.23</b>	<b>14,960,705.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,079,600.00	4,846,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	649,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	92,700.00
210807	Газрын төлбөр	20,650.00	20,650.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,677,860.00	6,851,680.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	967,511.23	0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,274,122.00</b>	<b>162,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,274,122.00	162,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,451,946,669.77</b>	<b>89,632,030,375.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,226,464,562.89</b>	<b>80,314,124,356.52</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	60,179,427,217.14	80,155,323,321.86
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,597,300.00	8,115,824.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,440,045.75	42,632,010.66
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	108,053,200.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>8,225,482,106.88</b>	<b>9,317,906,018.48</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,225,482,106.88	9,317,906,018.48
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>469,609,707.16</b>	<b>-682,010,143.36</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>469,609,707.16</b>	<b>-682,010,143.36</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,476,356,878.73	6,945,966,585.89
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,945,966,585.89	6,263,956,442.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	10,562,191,133.52	10,857,305,438.41
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	10,562,191,133.52	10,857,305,438.41
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	1,334,971,071.42	1,334,971,071.42
10	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	11,897,162,204.94	12,192,276,509.83
11	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	11,897,162,204.94	12,192,276,509.83
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-5,384,788.25	-5,384,788.25
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	11,891,777,416.69	12,186,891,721.58
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,933,492,952.73	1,933,492,952.73
20	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	13,825,270,369.42	14,120,384,674.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>81,651,505,900.00</b>	<b>80,955,965,610.76</b>	<b>695,540,289.24</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,651,505,900.00	80,955,965,610.76	695,540,289.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,748,400.00	684,763,264.90	57,985,135.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	595,497,200.00	548,532,200.64	46,964,999.36
210101	Үндсэн цалин	442,245,100.00	403,598,757.95	38,646,342.05
210102	Нэмэгдэл	93,366,500.00	92,809,686.01	556,813.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,181,600.00	26,004,000.00	6,177,600.00
210104	Урамшуулал	27,704,000.00	26,119,756.68	1,584,243.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,437,200.00	69,489,333.50	4,947,866.50
210201	Тэтгэврийн даатгал	50,617,300.00	47,638,347.59	2,978,952.41
210202	Тэтгэмжийн даатгал	5,954,900.00	5,689,808.78	265,091.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,764,000.00	4,588,189.24	175,810.76
210204	Ажилгүйдлийн даатгал	1,191,000.00	1,051,279.07	139,720.93
210205	Эрүүл мэндийн даатгал	11,910,000.00	10,521,708.82	1,388,291.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,731,400.00	27,540,701.91	190,698.09
210301	Гэрэл, цахилгаан	3,966,100.00	3,891,868.91	74,231.09
210302	Түлш, халаалт	21,900,900.00	21,900,900.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	1,864,400.00	1,747,933.00	116,467.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,221,400.00	20,625,723.85	1,595,676.15
210401	Бичиг хэрэг	6,080,400.00	6,079,960.00	440.00
210402	Тээвэр, шатахуун	11,645,000.00	10,050,900.00	1,594,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,788,600.00	1,787,463.85	1,136.15
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	332,400.00	332,400.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,375,000.00	2,375,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,355,400.00	2,343,600.00	11,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,405,400.00	1,405,300.00	100.00
210604	Урсгал засвар	950,000.00	938,300.00	11,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,109,000.00	1,109,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,109,000.00	1,109,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,834,800.00	14,960,705.00	3,874,095.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,957,500.00	4,846,000.00	2,111,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	649,675.00	325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	92,700.00	7,300.00

**Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	50,000.00	20,650.00	29,350.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,577,300.00	6,851,680.00	1,725,620.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>562,000.00</b>	<b>162,000.00</b>	<b>400,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	562,000.00	162,000.00	400,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,908,757,500.00</b>	<b>80,271,202,345.86</b>	<b>637,555,154.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>80,908,757,500.00</b>	<b>80,271,202,345.86</b>	<b>637,555,154.14</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	80,792,754,300.00	80,155,323,321.86	637,430,978.14
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,950,000.00	7,825,824.00	124,176.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	108,053,200.00	108,053,200.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>81,651,505,900.00</b>	<b>38,818,850,215.70</b>	<b>42,832,655,684.30</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>8,380,248,000.00</b>	<b>8,380,248,000.00</b>	<b>0.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	8,380,248,000.00	8,380,248,000.00	0.00
<b>33</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>73,271,257,900.00</b>	<b>30,343,805,480.76</b>	<b>42,927,452,419.24</b>
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	73,262,157,000.00	30,334,704,580.76	42,927,452,419.24
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,100,900.00	9,100,900.00	0.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0</b>	<b>94,796,734.94</b>	<b>-94,796,734.94</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	94,640,734.94	-94,640,734.94
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	156,000.00	-156,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	6,945,966,585.89	-6,945,966,585.89
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	6,263,956,442.53	-6,263,956,442.53
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>47</b>	<b>39</b>	<b>8</b>
620001	Удирдах ажилтан	1	1	8
620002	Гүйцэтгэх ажилтан	40	32	8
620003	Үйлчлэх ажилтан	6	6	8
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>47</b>	<b>39</b>	<b>8</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	41	32	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6	7	-1

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд “Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болно” гэсэн хэтийн зорилтыг тавьж ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Нийгмийн даатгалын тухай хуульд Нийгмийн даатгалын байгууллага дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ. Үүнд:

- 1/ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- 2/ нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;
- 3/ нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- 4 /улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- 5/ доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;
- 6/ хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын хяналт шалгалтын газраас болон хяналт, шалгалт дотоод аудитын тасгаас 2022 онд Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн сангийн үйл ажиллагаа болон үндсэн үйл ажиллагааны санхүүд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 190,437.3 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,945,966.6	6,263,956.4	(682,010.2)
Авлага	5,175,507.8	7,640,840.9	2,465,333.1
Урьдчилгаа			-
Бараа материал	10,219.4	6,477.0	(3,742.4)
Үндсэн хөрөнгө	325,698.4	381,682.0	55,983.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>12,457,392.2</b>	<b>14,292,956.3</b>	<b>1,835,564.1</b>
Өр төлбөр	91,947.3	83,642.8	(8,304.5)
Урьдчилж орсон орлого	173,168.4	88,928.8	(84,239.6)
Засгийн газрын оруулсан капитал	284,367.3	284,367.3	-
Хуримтлагдсан үр дүн	11,897,162.2	13,825,270.4	1,928,108.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,747.0	10,747.0	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>12,457,392.2</b>	<b>14,292,956.3</b>	<b>1,835,564.1</b>

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 6,263,956.4 мянган төгрөг болж оны эхнээс 682,010.2 мянган төгрөгөөр буурсан байна. Мөнгөн хөрөнгийн төрийн сан дахь ахмадын сангийн харилцах дансанд 2,091.5 мянган төгрөгийн, төрийн сан дахь ерөнхий орлогын дансанд 743.8 мянган төгрөгийн, арилжааны банк дахь дансанд 6,261,121.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэл 7,640,840.9 мянган төгрөг болж, 2,465,333.1 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд:

Төлбөртэй үйлчилгээний авлага дансны үлдэгдэлд 160 ажил олгогчийн 3,877,381.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Татаас санхүүжилтийн 3,704,531.1 мянган төгрөг авлагад 630 ажил олгогчийн 2021 оны нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт чөлөөлөлтийн улсын төсвөөс авах авлага байна.

Бусад авлага дансны 58,928.4 мянган төгрөгийн үлдэгдэлд 58,717.3 мянган төгрөгийн улсын байцаагчийн актаар тавигдсан тэтгэвэр, тэтгэмжийн авлага, илүү олгосон тэтгэвэр тэтгэмжийн авлага, 211.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,477.0 мянган төгрөг болж, 3,742.4 мянган төгрөгөөр буурсан нь 21,333.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,422.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 25,076.3 мянган төгрөгийн материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 381,682.0 мянган төгрөг болж, 55,983.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 71,494.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө балансаас баланст шилжүүлэн,

нийт 85,832.7 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч, дээд газрын шийдвэрээр 2,988.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, элэгдэл нь дууссан 71,691.3 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасан, дахин үнэлгээ хийж орлого авсантай холбоотой байна.

Өр төлбөрийн үлдэгдэл 83,642.8 мянган төгрөг болж 8,304.5 мянган төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 69,804.2 мянган төгрөгийн олгогдоогүй тэтгэмж, тэтгэвэр, 6,914.5 мянган төгрөгийн бусад өр, 6,924.1 мянган төгрөгийн халаалтын өрийн үлдэгдэл байна.

Урьдчилж орсон орлого дансанд урьдчилж орсон нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын үлдэгдэлтэй байна. Үүнд: Ажил олгогчийн 33,667.6 мянган төгрөг, сайн дурын даатгуулагчийн 55,261.2 мянган төгрөг, нийт 88,928.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 13,825,270.4 мянган төгрөг болж 1,928,108.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 03 дугаар тогтоолд зааснаар Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын сан тайлант онд 30,334.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 93.1 хувиар биелүүлсэн байна

*Төвлөрүүлэх орлого*

*/сая төгрөг/*

<b>Орлогын төрөл</b>	<b>Төлөвлөгөө</b>	<b>Гүйцэтгэл</b>	<b>Зөрүү</b>	<b>Хувь</b>
Тэтгэврийн даатгалын сан	26,616.3	24,917.8	1,698.5	93.6 %
Тэтгэмжийн даатгалын сан	2,653.7	2,591.4	62.3	97.6 %
ҮОМШӨ-ний даатгалын сан	2,777.9	2,329.2	448.7	83.5 %
Ажилгүйдлийн сан	523.8	496.3	27.5	94.7 %
<b>Нийт дүн</b>	<b>32,571.7</b>	<b>30,334.7</b>	<b>2,237.0</b>	<b>93.1 %</b>

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төсөв захирагчийн 2022 оны төсвийн төсөлд нийгмийн даатгалын сангийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 25,432.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 68,951.9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны урсгал төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 943.3 сая төгрөгөөр тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс санд төвлөрүүлэх орлогыг 6,897.7 сая төгрөгөөр өсгөж 32,330.4 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн зарлагыг 4,696.4 сая төгрөгөөр бууруулж 64,255.5 сая төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны төсвийг 96.1 сая төгрөгөөр бууруулж 847.2 сая төгрөгөөр баталсан бөгөөд 2022 оны 02 дугаар сарын 23, 6 дугаар сарын 07-д Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 02, 03 дугаар тогтоолоор дахин тодотгосон байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийг Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолтой холбоотойгоор өөрчлөлт оруулж тодотгосон төсвөөр нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх орлогыг 32,571.7 сая төгрөг, сангийн зардлыг 80,801.1 сая төгрөг, үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлэх төсвийг 850.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 81,651.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 81,651.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 850.4 сая төгрөгийг урсгал зардалд, 80,801.1 сая төгрөгийг санд зарцуулахаар батлагдсан.

Гүйцэтгэлээр нийт 89,634.8 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 36,287.0 сая төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 103.1 сая төгрөг, төвлөрүүлэх шилжүүлгийн 44,014.0 сая төгрөгийн орлого төвлөрч, нийгмийн даатгалын сангийн санхүүжилт 8,380.2 сая төгрөг, урсгал үйл ажиллагааны зардлын 850.4 сая төгрөгийн санхүүжилт авчээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 80,955.9 сая төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь урсгал үйл ажиллагааны зардалд 794.0 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг /нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж/ 80,161.9 сая төгрөг зарцуулж, үйл ажиллагааны зардлаас 56.4 сая төгрөг хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

Урсгал үйл ажиллагааны 9 хөтөлбөр арга хэмжээнд 850.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 794.0 сая төгрөг зарцуулж, хэмнэгдсэн 56.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна. Үүнд:

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	705,974.4	653,671.3	52,303.1	92.6
2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	5,670.0	3,869.5	1,800.5	68.2
3	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2,000.0	1,621.2	378.8	81.1
4	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хө	1,900.0	2,224.8	(324.8)	117.1
5	80219	Харуул, хамгаалалтын зардал	1,000.0	1,000.0	-	100.0
6	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	17,834.4	15,732.4	2,102.0	88.2
7	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	108,053.2	108,053.2	-	100.0
8	80813	Хуульд заасан үндэслэлээр алба	2,300.0	2,288.0	12.0	99.5
9	80820	Бусад тусламж, дэмжлэг	5,650.0	5,537.8	112.2	98.0
		<b>Дүн</b>	<b>850,382.0</b>	<b>793,998.2</b>	<b>56,383.8</b>	<b>93.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгээгүй байна.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 83 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 69,126,111,7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 691,261.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 518,445,8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад зөрчил илрээгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэлтийн горимыг баримталж ажиллан нийгмийн даатгалын санд 56.4 сая төгрөгийг хэмнэн төсөвт төвлөрүүлж ажилласан байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 47.0 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.9 сая төгрөг, тээвэр шатахуун 1.6 сая төгрөг, сургалтын зардал 0.4 сая төгрөг, тогтмол зардал 0.2 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, газрын төлбөр 0.2 сая төгрөг, Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын зардал 2.1 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

2022 онд нийт 9 албан тушаалын орон тооны дутагдалтай ажилласан байна. Төрийн албаны шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэн байхгүйн улмаас өндөр насны тэтгэвэрт

гарсан, жирэмсэн, амаржсан, хүүхдээ асрах чөлөө авсан ажилтны сул орон тоог нөхөхөд хүндрэл үүссэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг шалгахад мэдээллийг 100 хувьтай мэдээлсэн байна. Үүнд таван сая төгрөгөөс дээш орлогын 166,359,641.9 мянган төгрөгийн 2591 гүйлгээ, зарлагын 175,799,610.2 мянган төгрөгийн 2913 гүйлгээ, хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой 84,187.1 мянган төгрөгийн 8 тушаал шийдвэрийг мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

*Тухайн байгууллагад завсрын аудит хийгээгүй.*

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

*Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй тул өгөгдсөн зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт байхгүй.*

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,148.4 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 5,148.4 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд үлдэгдлийг 1,551.9 мянган төгрөгөөр илүү илэрхийлснийг залруулав.
2. Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1,903.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулав.
3. Санхүүгийн тайланд хувь хүний орлогын албан татварын авлагын үлдэгдлийг 1,692.7 мянган төгрөгөөр илүү илэрхийлснийг залруулав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгийг илүү илэрхийлсэн	1	1551.9	1	1551.9			1	1551.9				
Цалинг дутуу илэрхийлсэн	1	1903.8	1	1903.8			1	1903.8				
Авлагыг илүү тусгасан	1	1692.7	1	1692.7			1	1692.7				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>5148.4</b>	<b>3</b>	<b>5148.4</b>			<b>3</b>	<b>5148.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								